

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД,
НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд ээлтэй, хүртээмжтэй, чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө, мэдээллийг ил тод, нээлттэй байдлаар нийтэд хүргэх зорилгоор 2021-2023 онуудад хэрэгжүүлэх 5 зорилт, 22 арга хэмжээ бүхий “Шилэн эмнэлэг” хөтөлбөрийг эмнэлгийн захирлын 2021 оны А/39 дүгээр тушаалаар баталсан бөгөөд хэрэгжилт 98,1 хувийн биелэлттэй. ✓ Байгууллагын эрхэм зорилго, зорилт, алсын хараа, үнэт зүйлс тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг цаг тухай бүрд нь эмнэлгийн веб сайт, цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, иргэд үйлчлүүлэгчдэд ойлгомжтой байдлаар мэдээллийг хүргэн ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Веб сайтад нийт 21 төрлийн 170 гаруй мэдээ, мэдээлэл; • Цахим хуудсанд нийт 27 төрлийн 320 гаруй мэдээлэл нийтэлж 110,000 гаруй хүний хандалт; • Мэдээллийн самбарт нийт 13 төрлийн 35 мэдээлэл байршуулсан; 	100%
1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	<ul style="list-style-type: none"> ✓ ХЗДХСайдын 2022 оны н/169 дүгээр тушаалаар эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог шинэчлэн баталсан бөгөөд шинэчлэн баталсан дүрэм, бүтэц, орон тоог нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, эмнэлгийн захирлын 2022 оны н/03 дугаар тушаалаар бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг хийж, нийт ажилтан, албан хаагчдыг албан тушаалд томилсон. <ul style="list-style-type: none"> - Тус тушаалаар дараах алба, тасгийг шинээр зохион байгуулсан. Үүнд: Яаралтай тусламжийн тасаг, Эрүүл мэндийн дэмжих, урьдчилан сэргийлэх төв, Эмчилгээний хоол үйлдвэрлэлийн алба, өдрийн эмчилгээний алба, Эдийн засаг, статистик, төлөвлөлтийн алба, Мэдээллийн технологи, цахим бүртгэлийн алба - Эмнэлгийн захирлын 2022 оны А/176 дугаар тушаалаар эмнэлгийн хэмжээний албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх ажлын хэсгийн томилон ажиллуулсан. 	100%

		<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/183 дугаар тушаалаар эмнэлгийн хэмжээнд байгаа нийт 192 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан. 	
1.3.	<p>Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;</p>	<ul style="list-style-type: none"> ✓ “Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо MNS 27001:2015” стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ТЕГазрын Мэдээлэл аюулгүй байдлын газраар 4 хүний бүрэлдэхүүнтэй баг тус эмнэлгийн мэдээллийн аюулгүй байдлын бичиг баримт болон цахим системийн гэрээтэй танилцаж, цахим систем, дотоод, гадаад сүлжээ, сервер компьютеруудад нууцлал аюулгүй байдлын үнэлгээ хийж, зөвлөмжийг өгсөн. ✓ Нээлттэй мэдээлэл /хуулиар хаалттай, хязгаарлалттайгаас бусад мэдээлэл/-ийг эмнэлгийн фэйсбүүк хуудас, вэб сайт, твиттер хуудас, инстаграм хаяг, байгууллагын мэдээллийн самбар зэрэг мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийт 371 мэдээ мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөөг мэдээлэн ажилласан. ✓ Менежментийн тогтолцооны гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх тухай 2021 оны ТМ/06-34 дугаартай гэрээний хэрэгжилтийн хүрээнд тус эмнэлгийн Чанарын менежментийн тогтолцоонд Стандарт хэмжил зүйн газрын бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газраас магадлах аудитыг 09 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд хийж, сайжруулах 10 зөвлөмжийг өгсөн бөгөөд 01/2022 тоот дүгнэлтээр Гэрчилгээг үргэлжлүүлэн эзэмших, чанарын гарын авлага баталгаажсан. ✓ Стандарт хэмжил зүйн үндэсний төвийн баг тус эмнэлэгт төлөвлөгөөт магадлан шалгах явцын үнэлгээг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хийхэд үл тохирол илрээгүй бөгөөд нийт 3 зөвлөмж өгснийг 70%-тай хэрэгжүүлсэн. ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, түгээлт, мансууруулах сэтгэц нөлөөт эмийн хяналт зэрэг чиглэлээр дотоод хяналтыг 8 удаа, эргэн хяналт 4 удаа хийж, үр дүнг тооцсон бөгөөд нийт 6 удаа ил тод мэдээлж, ажлын байрны зөвлөмж 5 удаа өгч ажилласан. ✓ Эмнэлгийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг Эмнэлгийн захирлын 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн А/05 тушаалаар 21 бүлэг, 143 зүйл, 293 заалттайгаар баталсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй чиглэлээр тусгай бүлэг болгон оруулж өгсөн. (16 дугаар 	90%

		<p>бүлэг “Ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудал”)</p> <ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссыг Эмнэлгийн захирлын 2022 оны А/215 тоот тушаалаар Орон тооны бус байнгын комиссыг шинэчлэн байгуулж, дүрмийг батлуулж ажилласан. ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/97 дугаар тушаалаар НМХГазрын цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын хэлтсээс ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу “Эмнэлгийн цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм”-д өөрчлөлт оруулсан. 	
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/137 дугаар тушаалаар “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 чиглэлд 11 үйл ажиллагаатайгаар батлан, 93%-тай хэрэгжүүлсэн. 	93%
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	<ul style="list-style-type: none"> ✓ 2022 оноос эмнэлгийн үйл ажиллагаа гүйцэтгэлээр санхүүжих болсонтой холбогдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний төлөвлөлтийг (санхүүжилтийн хэмжээгээр) тасаг бүрээр хийж, ЭМДСангаас санхүүжих орлогын төлөвлөлтийг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлаар баталж, хэрэгжүүлж ажилласан. 	100%
1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/137 дугаар тушаалаар “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 чиглэлд 11 үйл ажиллагаатайгаар батлан, 93%-тай хэрэгжүүлсэн. ✓ Алба хаагч бүр “Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллаж байна. ✓ Эмнэлгийн хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль 	96.6%

		<p>тогтоомж, төрийн бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Жендерийн дэд зөвлөл”-ийг Эмнэлгийн захирлын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/180 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус зөвлөлөөс 2022 онд 10 арга хэмжээ төлөвлөж биелэлт 97 хувьтай.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн хэмжээнд залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийн чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Залуучуудын зөвлөл”-ийг эмнэлгийн захирлын 2021 оны А/36 дугаар тушаалаар 11 хүний бүрэлдэхүүнтэй баталсан. Эмнэлгийн захирлын 2021 оны А/81 дүгээр тушаалаар зөвлөлийн дүрэм, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 2021-2022 онд хэрэгжүүлэхээр баталж, 2022 оны хэрэгжилт 100 хувьтай. 	
1.7.	<p>Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;</p>	<ul style="list-style-type: none"> ✓ ХЗДХСайдын 2022 оны Н/169 дүгээр тушаалаар батлагдсан эмнэлгийн бүтэц, орон тоонд нэг цэгийн мэдээллийн болон кассын ажилтны орон тоог тусгасан бөгөөд эмнэлгийн захирлын 2022 оны А/183 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг батлан, ажиллуулсан. ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/176 дугаар тушаалаар эмнэлгийн хэмжээний албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх ажлын хэсгийн томилон ажиллуулсан. ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/183 дугаар тушаалаар эмнэлгийн хэмжээнд байгаа нийт 192 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан. ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны н/01 дүгээр тушаалаар эмнэлгийн түүхэн замналыг өгүүлэх бичил музейн (алдрын танхим) үйл ажиллагааг жигдрүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий музей хариуцсан ажилтныг томилж, албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй ажил үүрэг гүйцэтгэсний нэмэгдлийг сар бүр 40%-аар олгохоор шийдвэрлэсэн. ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны Б/222 дугаар тушаалаар музей хариуцсан ажилтныг шилжүүлэн томилж, албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй ажил үүрэг гүйцэтгэсний нэмэгдлийг сар бүр 35%-аар олгохоор шийдвэрлэсэн. 	100%

1.8.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	<ul style="list-style-type: none"> ✓ Үйлчилгээ, санал гомдол, асуудал хариуцсан ажилтны мэдээллийг цахим хуудаст болон мэдээллийн самбар, веб сайтад ил тод, нээлттэй байдлаар байршуулсан бөгөөд цахим хуудсаар ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэж хэвшсэн. Мөн түүнчлэн эмнэлгийн захиргаанаас иргэдийг хүлээн авах хуваарь гарган Эмнэлгийн захирлаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажилласан. ✓ Тус эмнэлэгт 2022 онд нийт 5 өргөдөл, 46 гомдол ирсэн байна. Нийт ирсэн өргөдөл, гомдлын хэлбэрээр нь авч үзвэл бичгээр-5, цахим хэлбэрээр – 7, утсаар -13, биечлэн уулзсан -2, олон нийттэй харилцах 11-11-т 24 гомдол ирсэн ба шийдвэрлэлт 98% байна. Эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 17.6%, Хүний нөөцийн асуудал холбоотой өргөдөл, гомдол– 82.4% эзэлсэн байна. 	93.4%
1.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээний статистик тоон үзүүлэлтийг 2022 оны сар бүрээр нь Мэдээллийн технологи, цахим бүртгэлийн алба, Эдийн засаг, статистик төлөвлөлтийн албатай хамтран инфографик байдлаар бэлтгэн, эмнэлгийн цахим хуудас, твиттер хуудас, вэб сайт болон эмнэлгийн ажилчдын дотоод группд мэдээлсэн бөгөөд давхардсан тоогоор 25 мянган гаруй хүний хандалт авсан. 	100%
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд ээлтэй, хүртээмжтэй, чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө, мэдээллийг ил тод, нээлттэй байдлаар нийтэд хүргэх зорилгоор 2021-2023 онуудад хэрэгжүүлэх 5 зорилт, 22 арга хэмжээ бүхий “Шилэн эмнэлэг” хөтөлбөрийг эмнэлгийн захирлын 2021 оны А/39 дүгээр тушаалаар баталсан бөгөөд хэрэгжилт 98,1 хувийн биелэлттэй. 	98.1%
Хэсгийн дундаж хувь:			97.1%
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> ✓ Албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд уг албан тушаалыг үндэслэн сонгон шалгаруулалт зарлаж, сул орон тоог 	90%

		<p>нөхөх арга хэмжээ авч байна. Тайлангийн хугацаанд сул орон тооны зарыг “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг” фэйсбүүк хуудас, зарын нэгдсэн сайт Зангиа.мн, эмнэлгийн цахим хуудас болон веб сайт, твиттер хуудас, инстаграм хаяг болон мэдээллийн самбарт байршуулж, нийт 24 удаа давхардсан тоогоор 69 төрлийн ажлын байрны сул орон тоог зарласан.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 34/31 дүгээр хамтарсан тушаалаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ыг баримтлан төрийн байгууллагын ажлын ачааллыг зохицуулах, төрийн албанд ажиллаж туршлага хуримтлуулсан албан хаагчийн мэдлэг, ур чадварыг үр өгөөжтэй ашиглах, дадлага, туршлагыг нь бусдад эзэмшүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор 1 албан хаагчийг Хил хамгаалах байгууллагаас сэлгэн авч томилсон. ✓ Ажлын байрны сул орон тоог зарлах, иргэдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Зангиа Портал” ХХК-тай 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 21/248 дугаартай гэрээ байгуулж, Зангиа.мн сайтад зар байршуулах эрх нээлгэж, хамтран ажиллаж байна. 	
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	<ul style="list-style-type: none"> ✓ Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14-р журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна. ✓ Зарын дагуу материал ирүүлсэн иргэдээс 12 удаагийн сонгон шалгаруулалт явуулж, 50 иргэнийг албан тушаалд томилж ажилласан. 	100%
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	<ul style="list-style-type: none"> ✓ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2022 оны А/105 дугаар тушаал “Салбарын алба хаагчдын ёс зүйн үлгэрчилсэн загварыг батлах ба түүний төрөөс зохиох ажлын талаар”, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаал “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ыг цахим хуудаснаа байршуулж мэдээлсэн. 	100%

		<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн ажилтан, албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, дүрэм, журмыг байгууллагын вэб сайт болон фэйсбүүк группт байршуулж, давхардсан тоогоор 61 мянга гаруй хүний хандалт авсан. ✓ Эмнэлгийн ёс зүйн хорооны мэдээллийг шаардлагатай хугацаанд бүрэн шинэчлэн цахим хуудаст байршуулан ажилласан. 	
2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн захирлын 2021 оны А/104 дүгээр тушаал “Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр 2021-2024 он” батлуулж, 2022 онд нийт 7 зорилт, 23 арга хэмжээг төлөвлөж, 97.4%-тай хэрэгжсэн. Үүнд: нийт 20 арга хэмжээг 100%, 1 арга хэмжээг 90%, 1 арга хэмжээ 80%, 1 арга хэмжээ 70%-тай тус тус үнэлсэн. 	97.4%
2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	<ul style="list-style-type: none"> ✓ Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр байгууллагын вэб хуудасны ил тод байдал хэсэгт хүний нөөцийн ил тод байдал нэртэй цэсийг шинээр нээж ажиллуулсан бөгөөд ажлын байрны сул орон тооны зар оруулахаас гадна ажилчдад нийтлэг урамшуулал олгох тухай тушаал, улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллын тушаал, шийдвэрийг байршуулж хэвшсэн. Улирал тутамд дээрх тушаалуудыг шинэчлэн байршуулдаг ба 2022 онд 4 удаа байршуулсан. 	100%
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/213 дугаар тушаалаар байгууллагын 2022 оны ажил дүгнэх комиссыг байгуулж, нийт ажилтан, албан хаагчдын ажлыг ил тод дүгнэн ажилласан. 2022 оны ажил, үйл ажиллагааг дүгнэх ажлын хэсгийг томилон ажиллуулж, ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэн ажилласан. ✓ Оны шилдэг алба, тасаг болон алтан зөгийн эзэд, гавьяа шагнал, цол хүртсэн алба хаагчдын мэдээллийг эмнэлгийн дотоод группт нийтэлж нийт ажилтан, алба хаагч нарт мэдээлсэн. Давхардсан тоогоор нийт 376 хүний хандалт авсан. ✓ 2022 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, эмнэлгийн хэмжээнд 	100%

		үзүүлсэн тусламж үйлчилгээ, гүйцэтгэлээр санхүүжих журмын хэрэгжилт зэрэг асуудлыг тусган ажилтан, албан хаагчдын ажлыг холбогдох журмын дагуу үнэлж, дүгнэж ажилласан бөгөөд уг үйл ажиллагааны талаар тухай бүр эмнэлгийн цахим хуудас болон дотоод сүлжээгээр дамжуулан нийт эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хүргэж, ил тод байдлыг ханган ажилласан.	
Хэсгийн дундаж хувь:			97.9%
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	<ul style="list-style-type: none"> ✓ Төсвийн урсгал төсөв болон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийг боловсруулах ажлын хэсгийг тасаг нэгжүүдийн 25 төлөөллийг оролцуулан Эмнэлгийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/104 тоот тушаалаар батлуулсан. ✓ 2023 оны төсвийн төсөл боловсруулж ХЗДХЯаманд хуулийн хугацаанд хүргүүлж хянуулсан. ✓ Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд 14,3 тэрбум төгрөг дүнтэй 5 төслийг бэлтгэн 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 856 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. 	100%
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайланг 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гарган, Үндэсний аудитын газар болон Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн бөгөөд 02 дугаар сарын 25-ны өдөр Үндэсний аудитын газраар баталгаажуулан зөрчилгүй санал дүгнэлт авсан. ✓ Байгууллагын 2021 оны баталгаажсан санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Сангийн яамны цахим систем болох www.e-balance.gov.mn-д шивж баталгаажуулан ХЗДХСайдын санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгүүлсэн. ✓ 2021 оны жилийн эцсийн тайлан, хувь хүнээс суутгасан орлогын албан татварын тайланг хуулийн хугацаанд гарган, цахим хуудсаар тайлагнасан. ✓ 2022 оны I, II, III улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 	100%

		гарган харьяалах дээд байгууллагад хүргүүлсэн бөгөөд 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаандаа гаргахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	✓ Эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийгдэж 2022.02.25-ны 12 дугаартай зөрчилгүй санал дүгнэлт бүхий аудитлагдсан тайланг шилэн дасны портал сайтад 2022 оны 04 дүгээр сард байршуулсан.	100%
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээний өртөг зардлыг тооцон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 4.4.2-т заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар тушаалыг үндэслэн иргэнээс авах төлбөрийн хэмжээг тогтоож, эмнэлгийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/100 дугаар тушаалаар “Төлбөрт тусламж үйлчилгээний журам”-ыг шинэчлэн баталж, шилэн дансны портал сайтад байршуулсан мөн өдрөөс өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	✓ Төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүрийн 02-ны дотор гарган ХЗДХЯ-ны төрийн сангаар баталгаажуулан байгууллагын ил тод байдлын самбарт 12 удаа, шилэн дансны портал сайтад сар бүр мэдээллэн ажилласан. Санхүүжилтийн эх үүсвэрийн гүйцэтгэл 92%-тай, зардлын гүйцэтгэл 74%-тай байна. Энэ нь урьд оны эх үүсвэрээс санхүүжих зарим арга хэмжээ, 2022 оны тендерийн эм, эмнэлгийн хэрэгслийн болон багаж техник хэрэгсэл худалдан авах 28 гэрээ он дамжин хэрэгжиж байгаа, мөн орон тоо гүйцэд ажиллаагүйтэй холбоотой байна.	100%
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	✓ Шилэн дансны портал сайтад хугацааны хувьд 5 ангилагдсан, 10 төрлийн 155 мэдээллээс 2022 оны 11 сарын байдлаар нийт 152 мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, өөрчлөлт орохгүй 3 мэдээг ажилтны буруугаас хугацаа хоцроосон төлөвт оруулсан байна. Гүйцэтгэл 98 хувьтай байна. Үүнд: - а/д Б.Оюунтөгс-1	100%

		<ul style="list-style-type: none"> - а/д М.Мөнхдэмбэрэл-1 - д/а Б.Манал-1 ✓ Төсөв гүйцэтгэл, тендер худалдан авалтын шалгаруулалтын урилга, тусламж үйлчилгээний тариф, мэдээ, мэдээлэл зэрэг нийт 5 нэр төрлийн мэдээ, мэдээллийг тус эмнэлгийн “Санхүүгийн ил тод байдлын самбар”-т сар бүр тогтмол буюу 55 удаа байршуулан ажилласан. Үүнээс 2022 оны байдлаар нийт 14 удаагийн мэдээ оруулахаас 12 удаагийн мэдээ, тайланг гарган Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулсан байна. 	
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	<ul style="list-style-type: none"> ✓ Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээг сар бүр хийж, баталгаажуулснаар 2022 оны байдлаар нийт 14 удаагийн мэдээ оруулахаас 12 удаагийн мэдээ, тайланг гарган Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулсан байна. 	100%
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	<ul style="list-style-type: none"> ✓ 2022 оны байдлаар нийт 14 удаагийн мэдээ оруулахаас 12 удаагийн мэдээ, тайланг гарган Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулсан байна. 	100%
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> ✓ 2022 оны байдлаар нийт 14 удаагийн мэдээ оруулахаас 12 удаагийн мэдээ, тайланг гарган Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулсан байна. 	100%
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй	<ul style="list-style-type: none"> ✓ 2022 оны байдлаар нийт 14 удаагийн мэдээ оруулахаас 12 удаагийн мэдээ, тайланг гарган Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулсан байна. 	100%

	оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан		
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	<ul style="list-style-type: none"> ✓ 2021 оны жилийн эцсийн Санхүүгийн тайланд хийгдсэн аудитын зөвлөмжийн дагуу биелэлтийг ханган ажиллаж, Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд 1 мэдээ байршуулсан байна. ✓ 2022 оны 11 дүгээр сард Үндэсний аудитын газраас Санхүүгийн явцын хяналт шалгалт хийгдсэн ба дүгнэлт гараагүй байгаа. 	100%
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	<ul style="list-style-type: none"> ✓ Тус эмнэлгийн 2022 оны батлагдсан төсвийн хүрээнд гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно. 	100%
3.15	Хууль тогтоомжид заасан бусад	<ul style="list-style-type: none"> ✓ Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, холбогдох журмыг үндэслэн байгууллагын Шилэн дансны цахим систем, байгууллагын вэб сайт, эмнэлгийн Мэдээллийн тод тод байдлын шилэн самбарт тус тус мэдээ, мэдээлэл, тайланг хавсралтын хамт байршуулж ажиллаж байна. 	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	<ul style="list-style-type: none"> ✓ Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг тогтмол өгч үйлчилсэн 	100%
4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон	<ul style="list-style-type: none"> ✓ Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл сунгуулсан. Гэрчилгээний дугаар 0004527 	100%

	болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа		
Хэсгийн дундаж хувь:			100%
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	✓ “Нойрны төв”-ийн үйл ажиллагааны патентын материалыг Оюуны өмчийн газарт хүргүүлж, баталгаажуулсан бөгөөд 30469 тоот “Батламж”-ийг 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр хүлээн авсан.	100%
5.2.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	✓ Төрийн мэдээллийн цахим мэдээллийн сангаас эмнэлгийн эзэмшил, ашиглалтад байгаа газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг нягтлан шалгаж, тулган баталгаажуулах ажлын хүрээнд эмнэлгийн нэр дээр бүртгэлтэй газрын мэдээллийг egazar.gov.mn цахим мэдээллийн санд бүртгүүлэхээр 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 448, 449, 450 тоот албан бичгээр харьяалах газрын асуудал эрхэлсэн байгууллагуудад хүргүүлэн QR кодоор бүртгэлжүүлсэн.	100%
5.3.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	<ul style="list-style-type: none"> ✓ 2022 онд харилцах дансаар нийт 419 байгууллага, хувь хүнтэй харилцсан бол үүнээс гэрээт байгууллага, хувь хүн 216 байна. ✓ 2022 оны мөнгөн кассаар 18865 хүн үйлчлүүлсэн. ✓ Эмнэлгийн 426 ажилтан албан хаагчдад үйлчилсэн байна. ✓ Тайлант хугацаанд урсгал зардлын 23,660.9 сая төгрөгийн төсвийг батлуулан шаардлагатай үед батлагдсан төсвийн хувиарт нийт 4 удаагийн өөрчлөлтийн саналыг хүргүүлэн шийдвэрлүүлсэн. 	100%
5.4.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах	✓ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, цахим шилжилтийн бодлого зорилттой уялдуулан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр цахимжуулалтыг үе шаттай нэвтрүүлж байгаатай холбогдуулан Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж буй “Хүний нөөцийн удирдлагын систем”, Сангийн яамнаас хэрэгжүүлж буй “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-ийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, системийн үйл ажиллагааны зааврыг мөрдөж ажиллахыг үндэслэн Эмнэлгийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/130 дугаар тушаалаар “Хүний нөөцийн	100%

<p>шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;</p>	<p>удирдлагын систем”-д хүний нөөцийн мэдээллийг байршуулах тушаал баталж, алба хаагчдын мэдээллийг үнэн зөв байршуулан, цалин хөлсний бүрэлдэхүүн, цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээллийг гүйцэт оруулж, цалингийн мэдээлэл алба хаагчдын цахим хаяг руу тогтмол илгээж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм, сонгон шалгаруулах журам, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам зэрэг мэдээллийг тус бүр 3 удаа байршуулсан. ✓ Нээлттэй мэдээлэл /хуулиар хаалттай, хязгаарлалттайгаас бусад мэдээлэл/-ийг эмнэлгийн фэйсбүүк хуудас, вэб сайт, твиттер хуудас, инстаграм хаяг, байгууллагын мэдээллийн самбар зэрэг мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийт 371 мэдээ мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөөг мэдээлэн ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - 8.2 дахь заалт: Байгууллагын эрхэм зорилго, зорилт, алсын хараа, чанарын бодлого, иргэд үйлчлүүлэгчдийн санал хүсэлт, өргөдөл, гомдол зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудас болон вэб сайтад байршуусан. - 8.3 дахь заалт: Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлд нийт 16 удаа 133 төрлийн ажлын байрны сул орон тооны зарыг эмнэлгийн цахим хуудас болон вэб сайт, твиттер хуудас, инстаграм хаяг болон мэдээллийн самбарт байршуулж, нийт 165,000 гаруй хандалт авсан. - Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм, сонгон шалгаруулах журам, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам зэрэг мэдээллийг тус бүр 3 удаа байршуулсан. - Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны ёс зүйн 12 хэм хэмжээ, Эмнэлгийн мэргэжилтний зан үйлийн 11 хэм хэмжээ, эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харилцах 16 хэм хэмжээ, ёс зүйн түгээмэл 18 хэм хэмжээ, ёс зүйн тулгуур 5 зарчим зэрэг эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг цахим хуудас болон вэб сайтад тус бүр 2 удаа 	
--	---	--

		<p>байршуулж мэдээлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - 8.4 дэх заалт: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зар мэдээлэл, шилэн дансны хөтлөлт мэдээлэл, дэмжлэг тусламж, хөрөнгө оруулалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, төсвийн хэмнэлт зэрэг хуульд заасан мэдээ, мэдээллийг цахим хуудсанд тухай бүрд нь байршуулж ажилласан. ✓ 8.5 дахь заалт: Хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх нийт 362 мэдээ, мэдээллийг түгээсэн бөгөөд эмнэлгийн үйл ажиллагаа болон шинэ технологи, инноваци, шинэ төрлийн мэс засал, тусламж үйлчилгээний талаарх нийт 187 мэдээлэл, ЭМБО 113 удаагийн зөвлөгөө, бусад төрлийн 62 мэдээллийг олон нийтэд өгч, сурталчилсан. 	
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> ✓ Эмнэлгийн 2022 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 22 нэр төрлийн 71,5 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгө нь цаашид ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан, акталж данснаас хасах, 37 нэр төрлийн 62,1 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох саналыг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 163 тоот албан бичгээр ХЗДХЯаманд хүргүүлж, ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн. ✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/178 дугаар “Хөрөнгө бэлтгэх тухай” тушаалаар тус эмнэлэгт хандиваар ирсэн 6 нэр төрлийн 69,3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө болон бараа материалыг бүртгэлд тусган ажиллаж байна. (Сангийн яамнаас 17,6 сая төгрөгийн үнэ бүхий суурин болон зөөврийн компьютер, хэвлэгч, ЭМЯамнаас 51,6 сая төгрөгийн үнэ бүхий ковид тест, автомакс хүлээн авсан) ✓ Мөнгөн хөрөнгө, үнэт цаас, бараа түүхий эд материал, машин техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, эд хогшил, хүнсний 	100%

		<p>зүйлийн хүлээн авалт, хадгалалт хамгаалалт зарцуулалтыг гардан хариуцдаг нийт 25 ажилтан, албан хаагчидтай “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-г 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан.</p> <p>✓ Эмнэлгийн захирлын 2022 оны А/111, А/207 дугаар тушаалаар эмнэлгийн 2022 оны хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллого явуулах болон улсын үзлэг тооллогод хамрагдах бэлтгэл ажлын хэсгийг томилон ажиллуулж, хагас жилийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр ТӨБЗГазарт хүргүүлсэн бөгөөд бүтэн жилийн тооцоо бодолтын ажил хийгдэж байна.</p> <ul style="list-style-type: none"> - 2022 оны III улиралд ТӨБЗГ-тай байгуулсан 2020 оны Өмч эзэмшлийн гэрээний биелэлтийг 96%-тай, онц дүгнүүлж гэрээний хугацааг шинэчлэн байгуулсан. <p>✓ Байгууллагын 2022 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогын комиссын ажлын хүрээнд нийт 28 нэгжийн 1262 нэр төрлийн 6484 ширхэг 51.713,6 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг нэг бүрчлэн тоолон нэгтгэж тооллогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn цахим хуудасны burtgel.pcsp.gov.mn холбоосонд байршуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын систем”-ийн программ хангамжид эмнэлгийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн мэдээллийг бүрэн оруулсан. - Төрийн мэдээллийн цахим мэдээллийн сангаас эмнэлгийн эзэмшил, ашиглалтад байгаа газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг нягтлан шалгаж, тулган баталгаажуулах ажлын хүрээнд эмнэлгийн нэр дээр бүртгэлтэй газрын мэдээллийг egazar.gov.mn цахим мэдээллийн санд бүртгүүлэхээр 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 448, 449, 450 тоот албан бичгээр харьяалах газрын асуудал эрхэлсэн байгууллагуудад хүргүүлэн QR кодоор бүртгэлжүүлсэн. 	
5.6.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл	✓ “Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо MNS 27001:2015”	90%

	ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ТЕГазрын Мэдээлэл аюулгүй байдлын газраар 4 хүний бүрэлдэхүүнтэй баг тус эмнэлгийн мэдээллийн аюулгүй байдлын бичиг баримт болон цахим системийн гэрээтэй танилцаж, цахим систем, дотоод, гадаад сүлжээ, сервер компьютеруудад нууцлал аюулгүй байдлын үнэлгээ хийж, зөвлөмжийг өгсөн.	
5.7.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2017/539 дүгээр дүгнэлтээр улсын комисс хүлээн авсан.	100%
5.8.	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	<ul style="list-style-type: none"> ✓ Хүний нөөцийн мэдээллийн “GREEN ERP” системийн талаар судалж, ХЗДХЯамнаас чиглэл авч ажилласан. ✓ Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж буй “Хүний нөөцийн удирдлагын систем”-ийг нэвтрүүлэх ажлыг ТЕГазрын 2022 оны 05 дугаар сарын 14-ний өрийн 585 тоот, ХЗДХЯамны 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 3/2643 тоот албан бичгийг тус тус үндэслэн зохион байгуулсан. <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн захирлын 2022 оны А/130 дугаар тушаалаар эмнэлгийн нийт идэвхтэй 399, идэвхгүй 167 (тэтгэвэрт гарсан, ажиллаас чөлөөлөгдсөн г.м) ажилтан, албан хаагчдын мэдээллийг тус системд байршуулсан. ✓ “Хүний нөөцийн удирдлагын систем”-ийг ашиглах, мэдээллийг оруулах, цалин бодох арга зүйгээр хангах сургалтыг ХЗДХЯамнаас зохион байгуулсан бөгөөд сургалтад эмнэлгийн удирдлага 3 удаа, ахлах нягтлан 3 удаа, цалингийн нягтлан болон хүний нөөцийн мэргэжилтнүүд 4 удаа тус тус хамрагдсан. 	100%
5.9.	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	✓ Нээлттэй мэдээлэл /хуулиар хаалттай, хязгаарлалттайгаас бусад мэдээлэл/-ийг эмнэлгийн фэйсбүүк хуудас, вэб сайт, твиттер хуудас, инстаграм хаяг, байгууллагын мэдээллийн самбар зэрэг мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийт 371 мэдээ мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөөг мэдээлэн ажилласан.	100%
Хэсгийн дундаж хувь:			98.8%
Хэрэгжилтийн дундаж хувь:			97.9%